



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.03.25 № 97
танай _____-ны № _____-т

“ЭРДЭНЭТ ШИНЖЛЭХ УХААН,
ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Г.ЭНХБАЯР ТАНАА

Дүгнэлт өгөхөөс татгалзсан

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийхээр төлөвлөсөн.

“Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзаж байна. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн ба өргөн тархсан гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд дүгнэлт өгөх хангалттай, зохистой аудитын нотолгоо олж авах боломжгүй байна.

Дүгнэлт өгөхөөс татгалзсан үндэслэл

“Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк” ОНӨААТҮГ нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангаа 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдөр 02/08 дугаартай албан бичгээр ирүүлсэн боловч аудитаас шаардсан санхүүгийн анхан шатны баримт, материалыг 2025 оны 03 дугаар сарын 25-ний өдрийг хүртэл ирүүлээгүй нь тайланд дүгнэлт өгөхөд хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах цаг хугацааг хязгаарлаж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 14-д заасантай нийцээгүй, Санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг”, “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх”, “Хэмжилт”, “Тасалбар болголт” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой байсан.

Гэвч, дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоо авах боломжгүй байна.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА